

# ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР, ЭХ ҮРСИЙН БАЯРЫН ӨДРӨӨР ЗОХИОН ЯВУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2018.06.05

Улаанжирэм

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг батлуулж доорхи арга хэмжээг зохион байгуулан явуулав.

## 1. Нээлтийн арга хэмжээ



2. “Алдарт эх” –ийн болзол хангасан ээжүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1,2 одонг гардуулав.



3. Сумын хүүхдийн төлөө зөвлөлөөс “Шилдэг хүүхэд” шалгаруулах журмын дагуу жил бүр шилдэг хүүхэд шалгаруулж, шагнаж урамшуулдаг уламжлалтай. Энэ жилийн шилдэг хүүхдээр Эрдэнэчулууны Лхагвадорж шалгарав.



4. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр сумын бүх төсөвт байгууллагууд болон Ж.Рэнцэнпүрэв захиралтай Тахилгат цагаан ТББ, Царс орд компани, Ж.Эрдэнэбаатар, Ц.Сосорсүрэн, Ж. Түшинтөгс нарын гэр бүл хүүхэд багачууддаа баярын бэлэг гардууллаа.



5. Эх үрсийн баярын өдрийг угтаж "Хамтарсан баг" "Хүүхдийн төлөө зөвлөл"-өөс санаачилан гэр бүлийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж 17 гэр бүлийн 36 хүн оролцлоо. Тус арга хэмжээг Ж.Түвшинтөгсийн гэр бүл 200 000 төгрөгөөр ивээн тэтгэв.



6. "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр өглөөний 8 цагаас 16 цагийн хооронд тээврийн хэрэгсэл зорчихгүй байх урилагыг сумын хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, цагдаагийн хэсэг гарган "Машингүй өдөр" –ийг 4 дэх жилдээ явуулж байна. Авто машингүй өдрийн гол зорилго нь бага насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, зам талбайд чөлөөтэй зорчих, уралдаан тэмцээнд оролцоход саад бэрхшээлгүй амар тайван байх нөхцөлийг бүрдүүлж байгаа билээ. Жолооч нар энэхүү арга хэмжээнд хүндэтгэлтэй ханддагаас гадна, орон нутгийн иргэд ч авто машингүй өдрийг маш сайшаалтайгаар хүлээн авдаг юм.



7. Жил бүрийн хүүхдийн баяраа сумын ИТХ, ЗДТГ-ын хамт олны гэр бүлүүд ивээн тэтгэж 1-9 ангийн сурагчдын дунд 3 насны ангиллаар дугуйн уралдааныг зохион явуулдаг билээ. Энэ жилийн дугуйн уралдаанд 25 хүүхэд оролцов. Энэ арга хэмжээ нь жилээс жилд өргөжин дугуй сонирхогч хүүхдийн тоо өсөж байна.



8. ЕБСургуулийн захиргаа, Ж.Түвшинтөгсийн гэр бүл жил бүр “Аав ээж би” тэмцээн зохион байгуулдаг. Энэ жилийн тэмцээнд нийт 8 гэр бүлийн баг тамирчид оролцов. Үүнээс: У.Бат -Эрдэний гэр бүл “Тэргүүн” байр, Э.Бат- Заяагийн гэр бүл “дэд байр”, Д. Мөнх-Эрдэний гэр бүл “гутгаар” байр-ыг тус тус эзлэв.



9. Сумын бөхийн холбоо, ЭМТ хамтран өсвөрийн бөхийн барилдаан зохион байгуулж 47 хүүхэд барилдав. Тэмцээний дүнг 3 насны ангиллаар явуулж шөвгийн 4-т үлдсэн 12 сурагчийг өргөмжлөл, медиал, үнэ бүхий зүйлээр шагнав. Шагналын санд 2170000 төгрөг зарцуулсан.





10. 9-р ангийн сурагч У.Баянзул, Б.Буянжаргал нарын хамтарсан “Сургуулийн хавар” урлагийн тайлан тоглолтыг ЕБС, соёлын төв хамтран зохион байгуулав.



ТАЙЛАН БИЧСЭН:

ЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

Г. ДОЛГОРМАА